



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (463)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *“Амны хөндийн эрүүл мэнд” үндэсний хэтөлбөр шинэчлэн батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- *Дэлхийн шуудангийн холбооны дүрмийн долдугаар нэмэлт протокол*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны есдүгээр сарын 14

№34 (463)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

556.	Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 286	1025
557.	Самбуугийн Ламбаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 287	1027
558.	Лэгцэгийн Өвгөнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 288	1027
559.	Балжиннямдын Балдангомбод Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 289	1027
560.	Ёндонжамцын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 290	1028
561.	Дүгэржавын Хандаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай	Дугаар 291	1028

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

562.	"Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай	Дугаар 150	1028
------	---	------------	------

Гурав. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

563.	Дэлхийн шуудангийн холбооны дүрэм		1036
564.	Дэлхийн шуудангийн холбооны дүрмийн долдугаар нэмэлт протокол		1041
565.	Шуудангийн санхүүгийн үйлчилгээний хэлэлцээр		1043

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Боловсролын салбарт олон жил идэвх дурдсан хүмүүсийг төрийн дээд одон, медалиар санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

- | | |
|---|---|
| 1. Натаагийн Болд - Нийслэлийн 40 дүгээр сургуулийн захирал | 3. Алтанбаярын Мөнгөнцэцэг - МУИС-ийн Ерөнхий ба аналитик химийн тэнхимийн багш |
| 2. Рэнцэнгийн Лхагвасүрэн - ЭМШУИС-ийн багш | 4. Лувсангийн Өнөр - Нийслэлийн 21 дүгээр сургуулийн багш |

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

- | | |
|---|---|
| 1. Содовын Алтан-Очир - Ховд аймгийн Зэрэг сумын дунд сургуулийн багш | 2. Дондовын Алтанцэцэг - Хан-Уул дүүргийн боловсролын ҮЭ-ийн холбооны дэд ерөнхийлөгч |
|---|---|

3. Заяатын Баасанжав - МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн багш
4. Цэрэндоржийн Басанжав - ШУТИС-ийн Барилгын инженерийн сургуулийн багш
5. Гончигсүрэнгийн Базарсад - Хэнтий аймгийн Батноров сумын сургуулийн захирал
6. Цэрэндоржийн Баяраа - Нийслэлийн 5 дугаар сургуулийн багш
7. Төмөрбаатарын Бор - Нийслэлийн 3 дугаар сургуулийн нийгмийн ажилтан
8. Нацагдоржийн Борхүү - СУИС-ийн тэнхмийн эрхлэгч
9. Доржийн Ганбаатар - ШУТИС-ийн МТС-ийн салбарын эрхлэгч, профессор
10. Дүгэржавын Гаравсамбуу - Нийслэлийн 68 дугаар сургуулийн бага ангийн багш
11. Авгаандоржийн Гарваа - Нийслэлийн Налайх дүүргийн Соёл, гэгээрэл, хүүхдийн хөгжлийн төвийн захирал
12. Тавхайн Даваахүү - Нийслэлийн Баянгол дүүргийн 73 дугаар сургуулийн багш
13. Түдэвдагвын Дарьсүрэн - Нийслэлийн 87 дугаар сургуулийн бага ангийн багш
14. Гомбосүрэнгийн Дулгормаа - Дорноговь аймгийн Иххэт сумын сургуулийн арга зүйч
15. Гүнчингийн Дорж - ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн ахлах багш, дэд профессор
16. Даржаагийн Доржсүрэн - Нийслэлийн 75 дугаар сургуулийн багш
17. Гомбын Жавзанхорлоо - Боловсролын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйч
18. Шалжийн Жигмэд - Нийслэлийн "Билэг-Оюу" сургуулийн дуу хөгжмийн багш
19. Шаравын Мягмар - МУИС-ийн багш

20. Бадамжавын Мядаг - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 3 дугаар сургуулийн багш
21. Аюушийн Норовлоо - Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын сургуулийн ахмад багш
22. Дугаржавын Отгонбаяр - ШУТИС-ийн Хүнс, биотехнологийн сургуулийн ахлах багш
23. Яндагийн Очирпүрэв - Говь-Алтай аймгийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн онолын багш
24. Шатарын Пүрэв - Нийслэлийн 1 дүгээр сургуулийн бага ангийн багш
25. Цэдэнбалжирын Саранчимэг - Нийслэлийн 79 дүгээр сургуулийн багш
26. Балжиннямын Содномпунцаг - Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын сургуулийн бага ангийн багш
27. Хайдавын Сольравдан - Нийслэлийн "Ирээдүй" цогцолборын 2 дугаар бага сургуулийн гүйцэтгэх захирал
28. Гончигийн Сүхбаатар - ШУТИС-ийн БИС-ийн багш, доктор, дэд профессор
29. Цэдэвийн Тэгшжаргал - Увс аймгийн Улаангом сумын 1 дүгээр сургуулийн багш
30. Самъяагийн Хоролжав - Нийслэлийн 28 дугаар сургуулийн сургалтын менежер
31. Гэндэнгийн Цэвэрэнжав - Сонгинохайрхан дүүргийн Ирээдүй цогцолборын 3-р бага сургуулийн багш
32. Жамбалын Хөхөө - Нийслэлийн 69 дүгээр сургуулийн ахмад багш
33. Дашбалхын Цэрэндэжид - Нийслэлийн 31 дүгээр сургуулийн бага ангийн багш
34. Намжилдоржийн Цэцгээ - Нийслэлийн 97 дугаар цэцэрлэгийн арга зүйч
35. Пүрэвийн Цэрэндэмид - Дорноговь аймгийн Замын-Үүд сумын сургуулийн багш

ХОДОЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Сономын Баатар - "Сан" дээд сургуулийн удирдах зөвлөлийн дарга
2. Дариймаагийн Бадамханд - Нийслэлийн 15 дугаар сургуулийн багш
3. Дэлгэрийн Батчулуун - Нийслэлийн "Голомт" цогцолбор сургуулийн сургалтын менежер
4. Төмөрчөдөрний Баяраа - Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 1 дүгээр сургуулийн багш
5. Цэрэндамбын Даваадоо - Нийслэлийн 62 дугаар сургуулийн захирал
6. Санжийн Долгор - Увс аймгийн Улаангом сумын 1 дүгээр сургуулийн багш
7. Дүгэржавын Доржоо - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны иргэн, ахмад багш
8. Махсэдийн Доржсүрэн - Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын сургуулийн захирал
9. Гэлэгсамдангийн Доржханд - Хэнтий аймгийн Норовлин сумын сургуулийн захирал
10. Лувсангийн Дулмаа - Нийслэлийн 15 дугаар сургуулийн сургалтын менежер
11. Дамдингийн Дэнсмаа - Нийслэлийн 1 дүгээр сургуулийн багш
12. Сономдашийн Жамбал - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Гэгээрэл хөгжлийн төвийн багш
13. Батсүрэнгийн Жавзмаа - Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын сургуулийн нийгмийн ажилтан
14. Балжирпунцагийн Жаргалсайхан - Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын цэцэрлэгийн багш
15. Лувсаншаравын Лхагвадорж - Хэнтий аймгийн Галшар сумын сургуулийн багш
16. Дашзэвэгийн Нансалмаа - Нийслэлийн Налайх дүүргийн Чандмань цогцолборын захирал
17. Галдангийн Нямзав - Дорноговь аймгийн Иххэт сумын сургуулийн багш
18. Рэнцэнгийн Отгон - Нийслэлийн Баянзүрх дүүргийн "Шавь" цогцолборын багш
19. Пүрэвийн Оюунбилэг - Дорнод аймгийн Хэрлэн сумын 3 дугаар цэцэрлэгийн тогооч
20. Дэмбэрэлгийн Өнөр - Өмнөговь аймгийн Гурвантэс сумын сургуулийн сургалтын менежер

21. Адьяагийн Сумъяа - Нийслэлийн 67 дугаар сургуулийн багш	73 дугаар сургуулийн багш	
22. Жигмэдийн Тамир - МУБИС-ийн Биологийн тэнхмийн багш	29. Чимэддэрэнгийн Цэрэндолгор - Дорнод аймгийн Хэрлэн сумын 12 дугаар сургуулийн багш	
23. Сүрэнгийн Төмөрбаатар - Увс аймгийн Тас сумын ахлах сургуулийн багш	30. Гомбосүрэнгийн Цэрэндулам - Увс аймгийн Боловсрол соёлын газрын дарга	
24. Жамсрангийн Товуусүрэн - Нийслэлийн 67 дугаар сургуулийн багш	31. Сономын Цэрэндэжид - Нийслэлийн 84 дүгээр сургуулийн багш	
25. Гэндэнгийн Ухнаа - ШУТИС-ийн профессорын багийн ахлагч	32. Батжаргалын Цэцэгбадам - Нийслэлийн 104 дүгээр цэцэрлэгийн багш	
26. Алтангэрэлийн Цагаандэлгэр - Багахангай дүүргийн "Хангай" цогцолбор сургуулийн бага ангийн багш	33. Авирмэдийн Энхтуяа - Нийслэлийн 3 дугаар сургуулийн багш	
27. Чойжилжавын Цогзолмаа - Нийслэлийн 73 дугаар сургуулийн багш	34. Батсүхийн Ягаанцэцэг - Нийслэлийн 87 дугаар сургуулийн багш	
28. Баасангийн Цэрэндолгор - Нийслэлийн	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ	Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 287

Улаанбаатар хот

Самбуугийн Ламбаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Монгол Улсад мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, боловсролын бүх шатны байгууллагын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаанд өөрчлөлт шинэчлэлт хийх, боловсрол, шинжлэх ухааны салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоход оруулсан хувь

нэмрийг нь үнэлж УИХ-ын гишүүн Самбуугийн Ламбаад Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

Лэгцэгийн Өвгөнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Монгол Улсын их сургуулийн физик-математикийн салбарт 47 жил үр бүтээлтэй ажиллаж, их, дээд болон дунд сургуулийн оюутан, сурагчид, математикийн багш нарт зориулсан сургалт, эрдэм шинжилгээний олон ном, бүтээл туурвиж, математикийн салбарт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа идэвх

зүтгэлийг нь үнэлж Монгол Улсын их сургуулийн Математик компьютерийн сургуулийн багш доктор, профессор Лэгцэгийн Өвгөнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

Балжиннямын Балдангомбод Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай

Хөдөө аж ахуйн их сургуулийн инженер механикийн тэнхимд 44 жил үр бүтээлтэй ажиллаж сургалт-судалгаа, эрдэм шинжилгээний олон ном, сурах бичиг, нэг сэдэвт бүтээл туурвиж, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ХАА-н үйлдвэрлэлийн инженер техникийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөдөө аж

ахуйн их сургуулийн зөвлөх профессор Балжиннямын Балдангомбод Монгол Улсын гавъяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Ендонжавын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Монгол хэлний хичээлээр авъяаслаг сурагчдыг сонгон суралцуулж, сургалтын шилдэг аргуудыг нэвтрүүлэн уламжлалт бичиг соёлоо дэлгэрүүлэх, Монгол бичгийн Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн 5 дугаар сургуулийн

монгол хэл, уран зохиолын багш Ендонжавын Эрдэнэцэцэгт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 8 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

Дүгэржавын Хандаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, багш, сурагчдын ажиллаж суралцах таатай орчинг бүрдүүлэн өсвөр үеийг сурган хүмүүжүүлэх, сургалтын арга барилыг боловсронгуй болгоход оруулсан хувь нэмрийг нь үнэлж нийслэлийн Сүхбаатар дүүргийн 58 дугаар

сургуулийн захирал Дүгэржавын Хандаад Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 6 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

"Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны тодорхой хэсгийн хэрэгжилтэд олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг чиглүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн дотоодын эх үүсвэрийг эрүүл мэндийн сайдын төсвийн багцад тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, Сангийн сайд Н.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нэрт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд хариуцан зохион байгуулж,

хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах арга хэмжээ авч хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн П улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайд үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Амны хөндийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 66 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Л.ГҮНДАЛАЙ

"АМНЫ ХӨНДИЙН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх нь хүний биеийн бүхий л эрхтэнд нөлөөлөх, байнгын голомтот халдварыг багасган эрүүлжүүлэх чухал хүчин зүйл гэж үзэж байна. Иймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу улс орнууд шүд, амны хөндийн зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, өвчлөлийг бууруулах талаар 2000-2020 онд хэрэгжүүлэх зорилготой хөтөлбөрийг гарган хэрэгжүүлж байна.

Хүн амын дийлэнх хувь нь хот суурин газар шилжин амьдарч, амьдралын хэв маяг, үндэсний уламжлалт дадал заншил өөрчлөгдсөн, нийт аймгийн 47.7 хувь нь фторын агууламж багатай үндэс үс хэрэглэж байгаагийн зэрэгцээ чихэрлэг, өтгөрүүлсэн, хийжүүлсэн ундааны хэрэглээ сүүлийн 20 гаруй жилд 2-3 дахин нэмэгдэж сүү, цагаан идээний хэрэглээ 40 гаруй хувиар буурсан, хүнсний бүтээгдэхүүний зөв сонголт, зохистой хэрэглээний талаархи хүн амын мэдлэг дадал хангалтгүй байгаа зэрэг нь шүд цоорох өвчин, цоорлын шүс гаралтай шүдний хатуу эдийн эмгэг, яс сийрэгжих өвчнийг үүсгэх гол шалтгаануудын нэг болж байна.

Шүд цоорох өвчний улмаас гүйлсэн булчирхайн үрэвсэл, зүрх судас, үе мөч, бөөрний өвчин зэрэг бие махбодийн бүрэлдэхүүний халдвар, харшлын өвчин үүсч даамжирдаг. Иймээс орчин үед шүд цоорох өвчнийг нэг талаас шүдээ арчлах, зүй зохиистой хооллох зэрэг амьдралын хэвшлээс шалтгаалдаг өвчин, нөгөө талаас нянгийн халдвараар үүсдэг, өвчтэй хүнээс эрүүл хүнд дамжин халдварладаг халдварт өвчин буюу халдварын голомт гэж үзэж байна.

Хүн ам, хүүхэд, залуучуудын дунд амны хөндийн эрүүл ахуйн талаархи мэдлэг хангалтгүй, шүдээ зөв арчлах дадал заншил бүрэн төлөвшиж чадаагүйгээс шүдний өвчин үүсч хүндрэх, шүдгүйдлийн улмаас захлах, хоол боловсруулах эрхтний үйл ажиллагаа хямрах төдийгүй нийгэмтэй харилцах өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа алдагдаж амьдралын чанарыг бууруулахад хүргэж байна.

Иймд амны хөндийн эрүүл мэндийн талаархи сургалт, сурталчилгааг хүн амын насны онцлог тохируулан тасралтгүй, цэгцтэй явуулахын зэрэгцээ тэднийг шүд, амны хөндийн эрүүл мэндээ хянаж дээшлүүлэх, хоол, хүнсний зүйлээ зөв зохиистой сонгон хэрэглэх дадал заншилтай болоход нь дэмжлэг болох эрүүл мэндийг дэмжигч нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлж эмчлэх арга хэмжээг дан ганц нүүр, амны нэрийн мэргэжлийн тусламжаар бус нийгэм, хамт олныг түшиглэсэн амны хөндийн эрүүл

мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг бий болгон өргөжүүлэх замаар хэрэгжүүлэх, энэ ажилд иргэд, хамт олны зүгээс оролцох оролцоог сайжруулах, амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эм, материал, хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, амны хөндийн эрүүл ахуйн чиглэлээр нийгэм, хамт олны дунд ажиллах хүний нөөцийг бэлтгэх, чадавхийг дээшлүүлэх нь чухал байна.

Амны хөндийн эрүүл мэндийн талаар бодлого, үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдээлэл, баримт нотолгоо ч хангалтгүй байгаа байна. Иймд шүд цоорох өвчний тархвар зүйн мэдээллийн тогтолцоог зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтын тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын Засгийн газраас 1999-2005 онд "Амны хөндийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлан хэрэгжүүлснээр шүд цоорох өвчний тархалт 24.4 хувиар, шүд цоорох өвчний эрчмийн үзүүлэлт 2.7-гоор тус тус буурч хөтөлбөрийн зорилт амжилттай хэрэгжин 18 настай бүх хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувийн жин 5 хувиар нэмэгдсэн хэдий ч шүд цоорох өвчнийг тууштай бууруулахад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн цорц арга хэмжээг үе шаттайгаар Өргөжүүлэн хэрэгжүүлэх явдал чухлаар шаардагдаж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, зарчим, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

2.1. Зорилго

Шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтыг сайжруулах, шүд, амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж сайжруулах, эрүүл зан үйл төлөвшихөд дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх, нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар хүн амын дунд шүд цоорох өвчний тархалтыг бууруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Зорилт

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

1/Зорилт нэг. Шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх, хянах үйл ажиллагааг удирдан зохицуулах тогтвортой механизмыг бүрдүүлнэ;

2/Зорилт хоёр. Амны хөндийн эрүүл мэндээ иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчнөөс сэргийлэх мэдлэг, дадалтай болоход дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлнэ;

3/Зорилт гурав. Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх, хянах үйл

ажиллагааг эрүүл мэндийн анхдагч шатлал (сум, өрхийн эмнэлэг)-ын тусламж, үйлчилгээтэй уялдуулах, нийгэм, хамт олны дунд амны хөндийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг бий болгож боловсронгуй болгоно.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь зарчмыг баримтална:

1/Иргэд, хамт олны чадавхийг дээшлүүлэх замаар амны хөндийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйл (хувь хүн, нийгэм-эдийн засаг, орчин)-ийг бууруулах, амны хөндийн эрүүл мэндэд ээлтэй орчин, үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход чиглэсэн салбар дундын хамтын ажиллагаанд тулгуурлана;

2/Амны хөндийн эрүүл мэндийн талархи бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлгээ хийхэд иргэд, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ;

3/Хүүхэд, өсвөр үеийнхнийг шүд цоорох өвчнөөс сэргийлэх, залуу, дунд насныханд шүд цоорох өвчнийг тууштай, тасралтгүй эмчлүүлэх, ахмад настанд шүд цоорох өвчнөөс шалтгаалсан шүдгүйдлийг нөхөн сэргээх замаар нийт хүн ам, өвчлөх эрсдэлтэй бүлэг болон өвчлөсөн хүнд чиглэсэн иж бүрэн хандлага, баримт нотолгоонд түшиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

4/Эрүүл мэндийн байгууллагын одоогийн бүтэц болон нөөцөд тулгуурлан шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих, нийгэм, хамт олонд тулгуурласан анхдагч шатлалын тусламж, үйлчилгээнд түлхүү анхаарч анхдагч шатлалын болон эмнэл зүйн тусламжийн уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангана;

5/Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл болон Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах зэрэг нийгмийн эрүүл мэндийн бусад хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай уялдуулан үр ашгийг дээшлүүлнэ.

2.4. Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн:

2.4.1. Нэгдүгээр зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн байдалд хяналт, тандалт хийх тогтолцоо бий болгон зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтын тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх, энэ чиглэлээр чадавхи бүрдүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж амны хөндийн эрүүл мэндийн бодлого, стратегид шаардлагатай өөрчлөлт хийж байх;

2/Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар нийгэм, хамт олны түвшинд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар, үр дүнгийн байдалд байнгын хяналт тавих боломж

бүхий статистик мэдээллийн шинэ үзүүлэлтийг эрүүл мэндийн мэдээллийн сүлжээнд нэвтрүүлэх, мэдээллийн сан байгуулах;

3/Зонхилон тохиолдох амны хөндийн өвчнөөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах мэргэжлийн толгойлох байгууллагыг тогтоох.

Хүрэх үр дүн: Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчинд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлсийн тархалт, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнгийн байдлыг хянан тандах тогтолцоо бий болж баримт нотолгоонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн бодлого, үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.

2.4.2. Хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх талаар хүн амд дараахь дадал, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн нийгмийн маркетингийн стратеги боловсруулж хэрэгжүүлнэ;

Хүнсний бүтээгдэхүүнийг зөв сонгон зохистой хэрэглэх талаар:

а/хүүхдийг хөхөөр хооллох;

б/хийжүүлсэн ундаа, саахар, чихэр, чихэрлэг бүтээгдэхүүнийг зүй зохистой хэрэглэх, тэдгээрийн хэрэглээг бууруулах;

в/сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх;

г/фтор агуулсан усыг орон нутгийн эмчийн зөвлөгөөний дагуу хэрэглэх ба үл хэрэглэх.

Амны хөндийн эрүүл ахуйг сахиух талаар:

д/фтортой оо, бэлдмэлийг орон нутгийн эмчийн зөвлөгөөний дагуу хэрэглэх болон үл хэрэглэх;

е/шүд, амны хөндийгөө зөв угаах, арчлах;

ж/шүд хамгаалах, бэхжүүлэх бүтээгдэхүүн, хэрэгслийг зохистой хэрэглэх арга барилд суралцах;

з/шүд, амны хөндийгөө өөрсдөө хянаж эмчид ханддаг болох.

2/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх талаар багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын агуулга, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, багшлах хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

3/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх талаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, эцэг, эхчүүдэд зориулсан аргачлал, гарын авлага гаргаж тэднийг богино хугацааны сургалтад хамруулан амны хөндийн эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтийн арга хэмжээнд татан оролцуулах;

4/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчний талаар үндэсний хэмжээний болон орон нутгийн байгууллага, хамт олон, бодлого

боловсруулагч, шийдвэр гаргагч нэрт зориулсан ухуулга-сурталчилгаа явуулан чадавхийг дээшлүүлэх замаар "Шүдэнд ээлтэй" үйлдвэрлэл, үйлчилгээ бий болгох;

5/Хийжүүлсэн ундаа, саахар, чихэр, чихэрлэг бүтээгдэхүүнийг зүй зохистой хэрэглэх, тэдгээрийн хэрэглээг бууруулах, сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, оновчтой болгох, татвар, импортын бодлого, зах зээлийн урамшууллын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Хүрэх үр дүн. Амны хөндийн эрүүл мэндэд ээлтэй нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн орчин бий болж амны хөндийн эрүүл мэндэд иргэд өөрсдөө хянаж дээшлүүлэх, шүд цоорох өвчин, түүний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх мэдлэг, дадалтай болно.

2.4.3. Гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.4.3.1. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ, амны хөндийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар:

1/Шүдний хатуулаг чанарыг дээшлүүлэх, шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ундны усны фортын агууламж нь бага орон нутагт фтортой бэлдмэлийн хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглээний нэгдсэн стандарт, аргачлал гаргаж хэрэгжүүлэх;

2/Шүд цоорох өвчний идэвхжиллийн сэргийл тодорхойлох сорил, шүдний фтортой гель, уусмалаар арчих, шүдний захлах гадаргуугийн ховил, хонхорхойг фтортой материалаар таглаж хамгаалах зэрэг шүд цоорох өвчнийг эрт илрүүлж хянах, эмчлэх энгийн, үр дүнтэй аргыг сургууль, байгууллага, аж ахуйн нэгж дээрх ажлын байр, баг, сум, өрхийн эмнэлгийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн суурь тусламжийн багц, стандартад тусган хэрэгжүүлэх;

3/Амны хөндийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг хянах, тандах талаар анагаах ухаан, сувилахуйн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;

4/Сувилагч, бага эмч нараас амны хөндийн эрүүл ахуйчийг төгсөлтийн дараахь сургалтаар бэлтгэж байгууллагад ажиллуулах;

5/Зонхилон тохиолдох амны хөндийн өвчний үед зайлшгүй шаардлагатай анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр баг, сум, өрхийн эмч, сувилагч нарыг сургалтад хамруулах.

2.4.3.2. Нуур амны эмнэл зүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар:

1/Амны хөндийн зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг шинэчлэн боловсруулж эрүүл

мэндийн тусламжийн бүх шатлалд мөрдүүлэх, тусламж, үйлчилгээний уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангах;

2/Шүд цоорлын хөнгөн үеийг өрөмдөлгүйгээр дахин эрдэсжүүлэн бэхжүүлж эмчлэх шинэ арга, технологийг орон нутагт нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, энэ чиглэлээр нүүр, амны мэргэжлийн болон сум, өрхийн эмч, сувилагч, амны хөндийн эрүүл ахуйч нарын мэдлэг, дадлыг дээшлүүлэх;

3/Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх болон нөхөн сэргээх орчин үеийн эм, бэлдмэл, материал, багаж, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх;

4/Орон нутаг, боловсрол, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага дээр "хүрч үйлчлэх" явуулын үйлчилгээ зохион байгуулах замаар нүүр, амны эмнэл зүйн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгоход чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

5/Шүд цоорох өвчнийг бүртгэх, хянах, эмнэл зүйн үйлчилгээнд хөндлөнгийн үнэлгээ хийх үйл ажиллагааг өргөжүүлэх;

6/Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх арга хэмжээний санхүүжилтийг боловсронгуй болгох.

Хүрэх үр дүн. Шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бий болж, түүний тасралтгүй байдал, чанар, хүртээмж нь дээшилнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

3.1. Хөтөлбөрийг 2006-2015 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд I үе шат 2006-2010 он, II үе шат 2011-2015 он байна.

3.2. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

1/Улс, орон нутгийн төсөвт тусгагдсан хөрөнгө;

2/Шинжлэх ухаан, технологийн сангаас олгох хөрөнгө;

3/Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

4/Олон улсын байгууллагын төслийн хөрөнгө, хандивлагч орны тусламж, хандив;

5/Бусад эх үүсвэр.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бусад салбарын оролцоог нэмэгдүүлж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл хүлээнэ.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах.

хяналт тавих ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжлийн бусад байгууллага (Улсын мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Нүүр ам судлалын сургууль, Шүд, эрүү нүүрний эмгэг судлалын төв зэрэг)-ыг татан оролцуулна. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн сайдын дэргэд хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсэг байгуулна.

4.3. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг даргаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүрэг бүхий салбар дундын ажлын хэсгийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулж ажиллуулна. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл нь орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн I улиралд багтаан тайлагнана.

4.4. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг нэгтгэн Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл, Засгийн газарт жил бүрийн I улиралд багтаан тайлагнана.

4.5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, хүлээх үүрэг.

4.5.1. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлийн байдалд хяналт, тандалт хийх тогтолцоо бий болгон зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн хяналт, тандалтын тогтолцоотой уялдуулан хөгжүүлэх, энэ чиглэлээр чадавхи бүрдүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлж

амны хөндийн эрүүл мэндийн бодлого, стратегид шаардлагатай өөрчлөлт хийж байх;

2/Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, шүд цоорох өвчин, түүнд нөлөөлөгч эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар нийгэм, хамт олны түвшинд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний чанар, үр дүнгийн байдалд байнгын хяналт тавих боломж бүхий статистик мэдээллийн шинэ үзүүлэлтийг эрүүл мэндийн мэдээллийн сүлжээнд нэвтрүүлэх, мэдээллийн сан байгуулах;

3/Зонхилон тохиолдох амны хөндийн өвчнөөс сэргийлэх, хянах нэгдсэн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах мэргэжлийн толгойлох байгууллагыг тогтоох;

4/Шүд, амны хөндийн зонхилон тохиолдох өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах үйл ажиллагаанд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нөөцийг дайчлах;

5/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжин удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах;

6/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын болон олон улсын байгууллага, хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлж байгаа бусад хөтөлбөр, төсөлтэй уялдуулах замаар хөтөлбөрийн үр дүнг нь дээшлүүлэх;

7/Амны хөндийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, зөв зохистой хооллох, шүд, амны хөндийгөө өөрсдөө хянах талаар мэдлэг, хандлага, дадал төлөвшүүлэхэд чиглэсэн албан, албан бус болон зайны сургалтын хөтөлбөр, гарын авлага, аргачлал, зөвлөмжийг холбогдох яам, газартай хамтран боловсруулж хэрэгжүүлэх;

8/Шүд цоорох өвчний үед үзүүлж байгаа эмнэл зүйн тусламж, үйлчилгээний дотор урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааны эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх чиглэлээр тусламж, үйлчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгох;

9/Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн

эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, зонхилон тохиолдох шүд, амны хөндийн өвчний оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээлтийн орчин үеийн арга барилд сургах чиглэлээр гадаад, дотоодод сургах, мэргэжлийг дээшлүүлэх;

10/Амны хөндийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар үр дүнд хүрч байгаа бусад орны туршлагыг судлах, өөрийн оронд нэвтрүүлэх арга хэмжээ зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

11/Зонхилон тохиолдох амны хөндийн өвчний оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийг эрүүл мэндийн тусламжийн шатлал бүрт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх;

12/Сум, өрхийн эмнэлгээс үзүүлэх анхдагч шатлалын тусламж, үйлчилгээг зонхилон тохиолдох шүд, амны хөндийн өвчнөөс сэргийлэх, хянах үйл ажиллагаатай уялдуулах, хөдөө орон нутаг, боловсрол болон үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад "хүрч үйлчлэх" замаар нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;

13/Зонхилон тохиолдох шүд, амны хөндийн өвчнөөс сэргийлэх, хянах талаар баримтлах бодлого, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хүн амын зан үйл, орчны өөрчлөлтийн байдалд судалгаа, үнэлгээ хийх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх;

14/Шүд, амны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн талаар баримт нотолгоонд тулгуурласан ухуулга сурталчилгаа явуулах, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарыг мэдээллээр хангах;

15/Амны хөндийн эрүүл мэнд, шүд цоорох өвчнөөс сэргийлэх талаар хүн амын насны онцлогт тохирсон гарын авлага гарган хүүхэд болон залуучууд, хүн амын дунд мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах;

16/Нүүр, ам судлалын тусламж үзүүлж байгаа улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтны амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, нийгмийн эрүүл мэндийн талаархи мэдлэг, дадлыг дээшлүүлэх, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах.

4.5.2. Гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Хөтөлбөр хэрэгжүүлэх талаар олон улсын байгууллага, хандивлагчидтай хамтран ажиллах;

2/Зонхилон тохиолдох шүд, амны хөндийн өвчнөөс сэргийлэх, хянах чиглэлээр баримтгалж байгаа бодлогыг хэрэгжүүлэх асуудлыг гадаад орон, олон улсын байгууллагад тавьж хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрт тусгаж хэрэгжилтэд хяналт тавих.

4.5.3. Хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх.

4.5.4. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Хийжүүлсэн ундаа, саахар, чихэр, чихэрлэг бүтээгдэхүүнийг зүй зохистой хэрэглэх, тэдгээрийн хэрэглээг бууруулах, сүү, цагаан идээний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн татварын бодлого хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

2/Амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг боловсронгуй болгох;

3/Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг эрүүл мэндийн салбарын төсөвт тусган санхүүжүүлж байх.

4/Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хөтөлбөрийн тодорхой үйл ажиллагааг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

4.5.5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, багшлах хүний нөөцийн чадавхийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авах;

2/Амны хөндийн эрүүл мэнд, эрүүл, зохистой хооллолтын талаар багш бэлтгэдэг их,

дээд сургууль, коллежийн сургалтын агуулга, хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;

3/Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хоол, цайны газруудыг цагаан идээ, жимс, ногооны зууш, халуун хоол зэрэг "Шүдэнд ээлтэй хоол, хүнсний бүтээгдэхүүн"-ээр үйлчилдэг болгох талаар холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

4/Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол, цайны дараа эмч, сувилагч, багш нарын хяналтын дор хүүхдийн шүдийг угаалгаж хэвшүүлэх боломж нөхцөлөөр хангах, эцэг, эхчүүдэд сургалт явуулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

5/Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, нийгэм, хамт олонд тулгуурласан амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, зонхилон тохиолдох шүд, амны хөндийн өвчний оношилгоо, эмчилгээ, нөхөн сэргээлтийн орчин үеийн арга барилд сургах чиглэлээр боловсон хүчнийг гадаад, дотоодод сургах, мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6/Амны хөндийн эрүүл мэнд, түүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийг хянах, тандах талаар анагаах ухаан, сувилахуйн мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх;

7/Амны хөндийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх талаар баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээний үр дүн, хүн амын зан үйл, орчны өөрчлөлтийн байдалд хийх судалгааны ажлын төслийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж санхүүжүүлэх;

8/Ерөнхий боловсролын сургуулийн эмч, сувилагч нарыг амны хөндийн эрүүл ахуйн сургалтад хамруулах, амны хөндийн эрүүл ахуйч-сувилагч (бага эмч) ажиллуулах;

9/Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг жилд нэгээс доошгүй удаа нүүр, амны нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулан шаардлагатай арга хэмжээг авч байх.

4.5.6. Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь энгийн саахарын хэмжээг бууруулах чиглэлээр стандартыг хянан шинэчлэн батлуулж мөрдүүлэх;

2/Шүдэнд ээлтэй хүнсний бүтээгдэхүүний шинэ нэр төрлийг үйлдвэрлэх, сурталчлах ажилд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

3/Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл үндэсний хөтөлбөрт сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэхээр тусгасан зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх.

4.5.7. Үйлдвэр, худалдааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Шүдэнд ээлтэй хүнсний бүтээгдэхүүн /саахар, чихэрлэг багатай-ий хэрэглээг дэмжсэн импорт, экспортын бодлого хэрэгжүүлэн хяналт тавих.

4.5.8. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Жилд нэгээс доошгүй удаа ажилчин, ажилтнаа нүүр, амны нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах арга хэмжээ авч байхыг ажил олгогчид даалгах, хэрэгжилтэд хяналт тавих;

2/Эмзэг бүлгийн хүүхдийн дунд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж шаардлагатай арга хэмжээ авч байх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих.

4.5.9. Батлан хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Зэвсэгт хүчний анги, салбаруудын эмч, сувилагч нарыг амны хөндийн эрүүл ахуйч бэлтгэх сургалтад хамруулан цэргийн албан хаагчдын дунд амны хөндийн эрүүл мэнд, зонхилон тохиолдох амны хөндийн өвчнөөс сэргийлэх чиглэлээр сургалт явуулах.

4.5.10. Улсын мэргэжлийн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага:

1/Амны хөндийн эрүүл ахуй, ариун цэвэр, хөлдвэр хамгааллын дэглэмийн талаар гарсан

хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авах;

2/Зонхилон тохиолдох шүд, амны өвчний оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих.

3/Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын байдалд хяналт- шинжилгээ хийх.

4.5.11. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага:

1/Ундны усны фторын агууламжид байнгын хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авах.

4.5.12. Стандартчилал, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага:

1/Хүнсний бүтээгдэхүүний найрлага дахь энгийн саахарын хэмжээг бууруулах чиглэлээр бүх стандартыг хянан шинэчлэх арга хэмжээ авах.

4.5.13. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

1/Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар орон нутгийн онцлогт тулгуурласан дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2/Шүд, амны хөндийн өвчнөөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх талаар байгууллага, хамт олны үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийг сурталчлах, урамшуулах арга хэмжээ авах.

4.5.14. Нийт аж ахуйн нэгж, байгууллага:

1/Шүд, амны хөндийн өвчнөөс сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх талаар ажилтан, ажиллагчдын мэдлэг, дэдлэг дээшлүүлэх сургалт явуулах, тэднийг зохион байгуулалттайгаар эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт жилд 1-2 удаа хамруулах.

2/Хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагааны чиглэлд нийцсэн шүдэнд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах.

4.5.15. Хэвлэл мэдээллийн байгууллага:

1/Чихэрлэг, өтгөрүүлсэн, хийжүүлсэн ундаа, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах

саахарын хүний биед үзүүлэх сөрөг нөлөө, эдгээр бүтээгдэхүүнийг зохистой хэрэглэх, улмаар хэрэглээг бууруулах, амны хөндийн эрүүл мэнд болон зохистой, эрүүл хооллолтыг дэмжихэд чиглэсэн энгийн, ойлгомжтой мэдээллийг олон нийтэд хүргэх, энэ чиглэлээр бусад байгууллагад дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.

4.5.16. Хүнсний үйлдвэр, зах, бүх төрлийн нийтийн хоолны газар:

1/Хоол, хүнсний бүтээгдэхүүн дэх чихэрлэгийн хэмжээг бууруулж үйлчлүүлэгчдэд ээлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах.

4.5.17. Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон бусад төрийн бус байгууллага:

1/Хийжүүлсэн ундаа, саахар, чихэр, чихэрлэг хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, зар сурталчилгаанд хяналт тавьж мэдээлэл, тайлбар хийх, шаардлагатай арга хэмжээг мэргэжлийн бусад байгууллагатай хамтран авч хэрэгжүүлэх;

2/Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд оролцох.

4.5.18. Иргэд, олон нийтийн оролцоо:

1/Хийжүүлсэн ундаа, саахар, чихэр, чихэрлэг хүнсний зүйлийг аль болохоор бага хэрэглэх, хэрэглэсний дараа амаа зайлах, сүү, цагаан идээ, жимс, хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэх, шүдээ зөв угааж арчлах, фтортой оо болон фтор агуулсан ус, бусад хүнсний бүтээгдэхүүнийг эмчийн зөвлөгөөний дагуу хэрэглэж хэвших, өөрсдөө үлгэрлэн хүүхдээ сургах.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг улсын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гүйцэтгэнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Үзүүлэлт		Одоогийн түвшин*		Хүрэх түвшин	
				2010	2015
Шүд цоорлын тархалт, эрчим					
1. Шүд цоорлын тархалт (хувиар)	5-6 настай хүүхдийн дунд	80.1	79.0	78.0	
	12 настай хүүхдийн дунд	62.0	61.0	60.0	
	Нийт хүн амын дунд	71.6	71.0	70.0	
2. Шүд цоорлын эрчим	5-6 настай хүүхдийн дунд	4.6	4.5	4.3	
	12 настай хүүхдийн дунд	1.94	1.9	1.8	
	Нийт хүн амын дунд	3.05	3.0	2.8	
3. 18 настай хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувь		67.5	70.0	72.5	

Тайлбар: *Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн Нүүр, ам судлалын сургуулиас 2004 онд хийсэн судалгааны дүн.

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН ХОЛБООНЫ ДҮРЭМ

(1969 оны Токио, 1974 оны Лаузан, 1984 оны Гамбург, 1989 оны Вашингтон, 1994 оны Сөүл, 1999 оны Бээжин, 2004 оны Бухарестын нэмэлт протоколоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан)

Удиртгал¹

Шуудангийн үйлчилгээний үр өгөөжтэй үйл ажиллагааны дүнд ард түмнүүдийн хоорондын харилцааг хөгжүүлэх болон соёл, нийгэм, эдийн засгийн салбарт олон улсын хамтын ажиллагааны эрхэм зорилтуудад хүрэхэд амжилт олоход хувь нэмрээ оруулах зорилгоор хэлэлцэн тохирогч орнуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид соёрхон батлах нөхцөлөөр энэхүү дүрмийг батлав.

Холбооны үүрэг нь дэлхийн шуудангийн үйлчилгээний чанарын үр ашигтай, тогтвортой хөгжлийг хангаж, дэлхийн хүмүүсийн хоорондын харилцааг дор дурдсан хэлбэрээр дэмжинэ:

- нягт холбогдсон сүлжээгээр шуудангийн нэг нутаг дэвсгэрийг бий болгож, түүгээр дамжуулан шуудангийн илгээмж чөлөөтэй солилцож байх баталгааг хангах;

- шударга, нийтлэг стандарт, технологийг хэрэглэж, ашиглахыг дэмжих;

- хувь нийлүүлэгчдийн хоорондох хамтын ажиллагаа, харилцан ойлголцлын баталгааг хангах;

- үр ашигтай техникийн хамтын ажиллагааг урамшуулах;

- хэрэглэгчдийн өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах арга хэмжээ авах.

IXЭСЭГ

Нийтлэг заалт

I Бүлэг

Ерөнхий заалт

1 дүгээр зүйл

Холбооны үйл ажиллагааны хүрээ болон зорилт

1. Энэ дүрмийг батлах орнууд Дэлхийн шуудангийн холбооны нэрийн дор нэгдэж, шуудангийн илгээмжийг солилцох шуудангийн нэг нутаг дэвсгэрийг үүсгэнэ. Холбооны бүх нутаг дэвсгэрт чөлөөтэй дамжин өнгөрүүлэх эрхийг бататгана.

2. Холбооны зорилго нь байгууллагын аюулгүй байдлыг хангах, шуудангийн үйлчилгээг сайжруулах, энэ салбарт олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

3. Холбоо нь түүний гишүүн орнуудад аль болох боломжийн хэрээр техникийн туслалцаа үзүүлэхэд оролцоно.

(1 bis) дүгээр зүйл²

Тодорхойлолтууд

1. Дэлхийн шуудангийн холбооны баримт бичгүүдийн зорилгоор дараахь нэр томъёо дор дурдсан утгатай байна:

1.1 Шуудангийн үйлчилгээ: Холбооны байгууллагаас цар хүрээг нь тодорхойлсон бүхий л шуудангийн үйлчилгээ. Шуудангийн үйлчилгээний гол үүрэг нь шуудангийн илгээмжийг хүлээн авах.

¹ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² Бухарестийн 2004 оны Конгрессоор танилцуулсан

ангилах, дамжуулах, хүргэх зэргээр гишүүн орнуудын нийгэм, эдийн засгийн тодорхой зорилтуудыг хангахад чиглэнэ.

1.2 Гишүүн орон: Дүрмийн 2 дугаар зүйлийг бүрэн хангах улс байна.

1.3 Шуудангийн нэг нутаг дэвсгэр (шуудангийн нэг буюу нэгэн ижил нутаг дэвсгэр): ДШХ-ны баримт бичгийн хэлэлцэн тохирогч талуудын захидал шууданг харилцан солилцох, чөлөөтэй дамжин өнгөрүүлэх, шуудангийн илгээмжийг нэг орноос нөгөө орон уруу өөрийн шуудангийн илгээмжийн нэг адил алагчлахгүйгээр дамжин өнгөрүүлэх зэрэг үүрэг.

1.4 Чөлөөтэй дамжин өнгөрүүлэх: нэг орноос ДШХ-ны гишүүн нөгөө орон уруу шуудангийн илгээмжийг тээвэрлэн өнгөрүүлж байгаа шуудангийн байгууллага нь уг илгээмжийг өөрийн орны шуудангийн илгээмжийн нэгэн адил нөхцлөөр дамжин өнгөрүүлэх үүрэг.

1.5 Захидал шуудангийн илгээмж: Конвенцид тодорхойлогдсон илгээмж.

1.6 Олон улсын шуудангийн үйлчилгээ: Баримт бичгүүдээр зохицуулагдах шуудангийн үйлчилгээ буюу үйл ажиллагаа; эдгээр үйлчилгээ буюу үйл ажиллагааны цогцыг хэлнэ.

2 дугаар зүйл

Холбооны гишүүд

Холбооны гишүүн орон гэдэг нь:

a Дүрэм хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн гишүүнчлэлийн статустай байгаа орнууд;

b 11 дүгээр зүйлийн дагуу гишүүнчлэл нь хүлээн зөвшөөрөгдсөн орнууд.

3 дугаар зүйл

Холбооны эрх мэдэл

Холбооны эрх мэдлийн хүрээ нь:

a гишүүн орнуудын нутаг дэвсгэрт;

b Холбооны нутаг дэвсгэрт үл хамаарах газарт гишүүн орнуудын байгуулсан шуудангийн алба;

c Шуудангийн үйл ажиллагааны хүрээнд гишүүн орноос хамааралтай байдаг Холбооны гишүүн бус орны нутаг дэвсгэр.

4 дүгээр зүйл

Онцгой харилцаа

Холбоонд үл хамаарах нутаг дэвсгэрт шуудангийн үйлчилгээг эрхэлж байгаа шуудангийн байгууллагууд шуудангийн бусад байгууллагад зуучлагч хийх үүрэгтэй. Конвенцийн заалтууд болон түүний зохицуулалтуудыг тийнхүү онцгой харилцахад хэрэглэнэ.

5 дугаар зүйл

Холбооны байршил

Холбоо болон түүний байнгын үйл ажиллагаатай газрууд нь Берн хотноо байрлана.

6 дугаар зүйл

Холбооны албан ёсны хэл

Холбооны албан ёсны хэл нь франц хэл байна.

7 дугаар зүйл¹

Мөнгөний нэгж

Холбооны баримт бичгүүдэд хэрэглэгдэх мөнгөний нэгж нь Олон улсын валютын сан (ОУВС)-ийн санхүүгийн нэгж байна.

8 дугаар зүйл

Бүсийн байгууллагууд. Тусгай хэлэлцээр

1. Хэрэв гишүүн орнуудын хууль тогтоомжид харшлахгүй бол тухайн орнууд буюу тэдгээрийн шуудангийн байгууллагууд Бүсийн байгууллага үүсгэх болон олон улсын шуудангийн үйлчилгээтэй холбогдох тусгай хэлэлцээр байгуулж болох бөгөөд тэдгээр нь гишүүн орнуудын оролцогч тал болох Баримт бичгийн заалтуудад тусгаснаас дагуугүй тааламжтай нөхцөл олгоно.

2. Бүсийн байгууллага нь Конгресс, Бага хурал болон уулзалтууд, Захиргааны зөвлөл, Шуудангийн ашиглалтын зөвлөлд ажиглагчаа илгээж болно.²

3. Холбоо нь Конгресс, Бага хурал болон Бүсийн байгууллагын уулзалтуудад ажиглагчаа илгээж болно.

9 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагатай харилцах харилцаа

Холбоо нь Нэгдсэн Үндэстний Байгууллагатай харилцах харилцаанд энэ дүрэмд хавсаргасан хэлэлцээрүүдийг удирдлага болгоно.

10 дугаар зүйл

Олон улсын байгууллагуудтай харилцах харилцаа

Олон улсын шуудангийн үйл ажиллагааны хүрээнд нягт хамтын ажиллагааг хангах үүднээс Холбоо нь сонирхол, үйл ажиллагааныхаа дагуу Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

¹ 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² 1969 оны Токио, 1994 оны Севулийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

II Бүлэг

**Холбоонд нэгдэн орох буюу элсэх.
Холбооноос гарах**

11 дүгээр зүйл¹

Холбоонд нэгдэн орох буюу элсэх. Журам

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн аль ч улс Холбоонд нэгдэн орж болно.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус тусгаар тогтносон аль ч орон Холбооны гишүүн орон болж элсэх хүсэлтээ мэдүүлж болно.

3. Холбоонд гишүүнээр нэгдэн орох буюу элсэх хүсэлтээ мэдүүлэхдээ Дүрэмд нэгдэн орох болон Холбооны баримт бичгүүдийг биелүүлэх тухай албан ёсны мэдэгдэл үйлдэх ёстой. Энэ нь холбогдох улсын засгийн газраас нэгдэн орсныг мэдэгдэх, эсхүл зарим тохиолдолд элсэх тухай мэдүүлгийн талаар гишүүн орнуудтай зөвлөлдөх Олон улсын товчооны Ерөнхий захиралд хандсан мэдэгдэл байна.

4. Хэрэв Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн бус орны мэдүүлгийг Холбооны гишүүн орнуудын наад зах нь гуравны хоёроос илүү хувь нь батласан бол түүнийг гишүүн орон болж элслээ гэж үзнэ. Дөрвөн сарын дотор хариу мэдэгдээгүй гишүүн орнуудыг санал өгөхөөс түтгэлзсэн гэж үзнэ.

5. Олон улсын товчооны Ерөнхий захирал нэгдэн орсон буюу гишүүнээр элссэн тухай гишүүн орнуудын засгийн газарт мэдэгдэнэ. Уг мэдэгдлийг хийсэн өдрөөс эхлэн гишүүнчлэл хүчин төгөлдөр болно.

12 дугаар зүйл²

Холбооноос гарах. Журам

1. Холбогдох улсын засгийн газраас Дүрмийг цуцлах тухай мэдэгдлийг Олон улсын товчооны Ерөнхий захиралд өгснөөр болон тэрбээр гишүүн орнуудын засгийн газарт энэ тухай мэдэгдсэнээр гишүүн орон бүр Холбооноос гарч болно.

2. Холбооноос гарах шийдвэр нь 1 дэх хэсэгт заасны дагуу цуцлах тухай мэдэгдлийг Олон улсын товчооны Ерөнхий захирал хүлээн авсан өдрөөс хойш 1 жилийн дараа хүчин төгөлдөр болно.

III Бүлэг

Холбооны зохион байгуулалт

13 дугаар зүйл³

Холбооны байгууллагууд

1. Холбооны байгууллагууд нь Конгресс, Захиргааны зөвлөл, Шуудангийн ашиглалтын

зөвлөл, Олон улсын товчоо болно.

2. Холбооны байнгын үйл ажиллагаатай байгууллагууд гэж Захиргааны зөвлөл, Шуудангийн ашиглалтын зөвлөл, Олон улсын товчоог хэлнэ.

14 дүгээр зүйл

Конгресс

1. Конгресс нь Холбооны дээд байгууллага болно.

2. Конгресс нь гишүүн орнуудын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

15 дугаар зүйл

Ээлжит бус конгресс

Холбооны гишүүн орнуудын наад зах нь гуравны хоёрын хүсэлтээр буюу зөвшөөрснөөр Ээлжит бус конгрессийг хуралдуулж болно.

16 дугаар зүйл

Захиргааны хурал

(хасагдсан)⁴

17 дугаар зүйл⁵

Захиргааны Зөвлөл

1. Захиргааны зөвлөл (ЗЗ) нь Холбооны баримт бичгүүдэд заасны дагуу Конгрессуудын хооронд Холбооны ажлыг үргэлжлүүлэн явуулна.

2. Захиргааны зөвлөлийн гишүүд өөрсдийн чиг үүргээ Холбооны нэрийн өмнөөс болон ашиг сонирхлын дагуу хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл⁶

Шуудангийн ашиглалтын зөвлөл

Шуудангийн ашиглалтын зөвлөл (ШАЗ) нь шуудангийн үйлчилгээтэй холбоотой үйл ажиллагаа, арилжаа, техникийн болон эдийн засгийн асуудлыг хариуцна.

19 дүгээр зүйл⁷

Тусгай хороо

(хасагдсан)

20 дугаар зүйл⁸

Олон улсын товчоо

Холбооны байрлаж буй газарт Ерөнхий Захирлаар удирдуулсан Олон улсын шуудангийн холбооны Олон улсын товчооны нэрийн дор болон Захиргааны зөвлөлийн хяналтан дор үйл ажиллагаагаа явуулах төв алба нь гүйцэтгэх, дэмжлэг үзүүлэх, холбоо тогтоох, мэдээлэл болон зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлдэг байгууллага байна.

¹ 1969 оны Токио, 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

³ 1969 оны Токио, 1984 оны Гамбург, 1994 оны Сөүлийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁴ 1984 оны Гамбургийн Конгрессоор

⁵ 1994 оны Сөүлийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁶ 1969 оны Токио, 1994 оны Сөүлийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁷ 1984 оны Гамбургийн конгрессоор

⁸ 1984 оны Гамбург, 1994 оны Сөүлийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

IV Бүлэг

Холбооны санхүү

21 дүгээр зүйл¹

Холбооны зардал.

Гишүүн орнуудын хандив

1. Конгресс бүр дор дурдсан зүйлийн хамгийн дээд хэмжээг тогтооно;

а. Холбооны тухайн жилд гарч болох зардал.

б. Дараагийн Конгрессийг зохион байгуулахтай холбоотой зардал.

2. 1 дэх хэсгийн заалтад тусгагдсан зардлын дээд хэмжээ нь зайлшгүй тохиолдолд Ерөнхий журмын холбогдох заалтын үндэслэлээр тогтоосон хэмжээнээс хэтэрч болно.

3. 2 дахь хэсэгт дурдсан гарах зардлыг оролцуулан Холбооны зардлыг Холбооны гишүүн орнуудын хамтын санхүүжилтээр нөхнө. Энэ зорилгоор гишүүн орон бүр төлөвлөгөөнд тусгасан хандивын ангиллаа сонгоно. Гишүүн орноос өгөх ёстой хандивын ангиллыг Ерөнхий журмаар тогтооно.

4. 11 дүгээр зүйлийн дагуу Холбоонд нэгдэн орох буюу элсэх тохиолдолд холбогдох тухайн орон Холбооны зардлыг хуваарилсан хандивын хүссэн ангиллаа чөлөөтэй сонгоно.

II ХЭСЭГ

Холбооны баримт бичгүүд

I Бүлэг

Ерөнхий заалт

22 дугаар зүйл

Холбооны баримт бичгүүд

1. Дүрэм нь Холбооны үндсэн баримт бичиг болно. Дүрэм нь Холбооны гол журмыг тогтоох бөгөөд **түүнд тайлбар хийхгүй**.²

2. Ерөнхий журам нь Дүрмийг хэрэгжүүлэх болон Холбооны ажиллах журмыг хангах заалтуудыг тусгана. Түүнийг гишүүн бүх орон дагаж мөрдөх ёстой бөгөөд **түүнд тайлбар хийхгүй**.³

3. Дэлхийн шуудангийн холбооны дүрэм, Шуудангийн захидлын журам, Шуудангийн илгээмжийн журам нь олон улсын шуудангийн үйлчилгээнд хэрэглэх дүрэм болон шуудангийн захидал, шуудангийн илгээмжийн үйлчилгээтэй

холбоотой хэм хэмжээг тусгана. Баримт бичгүүд нь гишүүн бүх орны хувьд заавал биелэгдэх хүчин төгөлдөр байна.⁴

4. Холбооны хэлэлцээр болон түүний журмууд нь оролцогч тал болох гишүүн орнуудын хоорондох шуудангийн захидал болон шуудангийн илгээмжээс бусад үйлчилгээг зохицуулна. Мөн эдгээр нь зөвхөн тухайн орнуудад хүчинтэй байна.

5. Дүрэм болон хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмыг тусгасан зохицуулалтуудыг Шуудангийн ашиглалтын зөвлөл батлах бөгөөд чингэхдээ Конгрессоос гаргасан шийдвэрүүдийг харгалзан үзнэ.⁵

6. 3, 4, 5 дахь хэсгийн заалтад тусгагдсан Холбооны баримт бичгүүдэд хавсаргасан Төгсгөлийн протоколууд нь эдгээр баримт бичигт хийх тайлбарыг тусгана.

23 дугаар зүйл⁶

Олон улсын харилцаанд гишүүн орны хариуцсан нутаг дэвсгэрт Холбооны баримт бичгийг хэрэглэх.

1. Холбооны баримт бичиг нь олон улсын харилцаанд хариуцсан нутаг дэвсгэрт бүхэлд нь, эсхүл зөвхөн тодорхой хэсэгт нь үйлчлэх талаар аливаа орон түүнд нэгдэн орох аль ч үед мэдэгдэж болно.

2. 1 дэх хэсэгт дурдсан мэдэгдэл нь Олон улсын товчооны Ерөнхий захиралд хандсан байх ёстой.

3. 1 дэх хэсэгт заасан мэдэгдлийн хувьд гишүүн аль ч орон ямар ч үед Олон улсын товчооны Ерөнхий захиралд хандаж Холбооны баримт бичгүүдийг цуцлах тухай чиг санаа агуулсан мэдэгдлийг мөн хийж болно. Уг мэдэгдлийг Олон улсын товчооны Ерөнхий захирал хүлээн авсан өдрөөс хойш 1 жилийн дараа тэр нь хүчин төгөлдөр болно.

4. 1 болон 3 дахь хэсэгт заасан мэдэгдлийн талаар Олон улсын товчооны Ерөнхий захирал гишүүн орнуудад мэдэглэнэ.

5. 1-ээс 4 хүртэлх хэсгийн заалтууд нь Холбооны гишүүний статустай орны олон улсын харилцаанд хариуцсан нутаг дэвсгэрт хэрэглэгдэхгүй.

24 дүгээр зүйл

Үндэсний хууль тогтоомж

Холбооны баримт бичгүүдээр шууд заагаагүй ямар ч зүйлийн хувьд эдгээр баримт бичгийн заалт гишүүн аливаа орны үндэсний хууль тогтоомжоос доогуур нөхцөл олгохгүй.

¹ 1969 оны Токио, 1974 оны Лаузан, 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

³ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁴ 1999 оны Бээжингийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁵ 1989 оны Вашингтон, 1994 оны Сеул, 1999 оны Бээжингийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁶ 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

II Бүлэг

Холбооны баримт бичгийг хүлээн зөвшөөрөх болон цуцлах

25 дугаар зүйл¹

Холбооны баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, соёрхон батлах болон түүнийг батлах бусад хэлбэр

1. Конгрессоос батласан Холбооны баримт бичгүүдэд гишүүн орны бүрэн эрхт төлөөлөгч гарын үсэг зурна.

2. Журмуудыг Шуудангийн ашиглалтын зөвлөлийн Дарга болон Ерөнхий нарийн бичгийн дарга баталгаажуулна².

3. Гарын үсэг зурсан орнууд Дүрмийг аль болох богино хугацаанд соёрхон батлана.

4. Дүмээс бусад Холбооны баримт бичгүүдийг батлахдаа гарын үсэг зурсан орон бүр Үндсэн хуулийнхаа журмыг удирдлага болгоно.

5. Хэрэв аливаа орон Дүрмийг соёрхон батлаагүй, мөн гарын үсэг зурсан Холбооны бусад баримт бичгийг батлаагүй бол Дүрэм болон бусад баримт бичиг нь тэдгээрийг соёрхон батласан буюу батласан бусад орны хувьд бүрэн хүчин төгөлдөр байна.

26 дугаар зүйл³

Холбооны баримт бичгийг соёрхон батласан болон түүнийг батласан бусад хэлбэрийн талаар мэдэгдэх

Дүрэм болон түүний нэмэлт протоколуудыг соёрхон батласан, шаардлагатай үед Холбооны баримт бичгийг батласан тухай батламж жуух бичгийг Олон улсын товчооны Ерөнхий захиралд аль болох хурдан хадгалуулах бөгөөд тэрбээр ийнхүү хадгалуулсан тухай гишүүн орнуудын засгийн газарт мэдэгэлнэ.

27 дугаар зүйл

Хэлэлцээрт нэгдэн орох

1. Гишүүн орнууд 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу нэг буюу түүнээс дээш тооны хэлэлцээрт ямар ч үед нэгдэн орж болно.

2. 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцээрт нэгдэн орсон гишүүн орнуудын талаар мэдэгэлнэ.

28 дугаар зүйл

Хэлэлцээрийг цуцлах

12 дугаар зүйлд заасан нөхцлийн дагуу гишүүн аль ч орон нэг буюу түүнээс дээш тооны хэлэлцээрт оролцогч тал байхаа больж болно.

III Бүлэг

Холбооны баримт бичигт оруулах нэмэлт өөрчлөлт

29 дүгээр зүйл

Санал танилцуулах

1. Гишүүн орны шуудангийн байгууллага нь тухайн орны оролцогч тал болсон Холбооны баримт бичгүүдтэй холбогдсон саналыг Конгресст буюу Конгрессуудын хооронд гаргах эрхтэй.

2. Гэхдээ Дүрэм болон Ерөнхий журамтай холбогдох саналыг зөвхөн Конгресст л хүргүүлнэ.

3. Түүнчлэн Журмуудтай холбогдох саналыг Шуудангийн ашиглалтын зөвлөлд шууд хүргүүлэх бөгөөд эхлээд Олон улсын товчоогоор дамжуулан гишүүн бүх орны шуудангийн захиргаанд хүргүүлэх ёстой.⁴

30 дугаар зүйл

Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт

1. Дүрэмтэй холбоотой Конгресст хүргүүлсэн саналыг Холбооны гишүүн санал өгөх эрхтэй орнуудын гуравны хоёроос багагүй хувь нь дэмжсэнээр батлана.⁵

2. Конгрессоос батласан нэмэлт өөрчлөлт нь нэмэлт протоколын хэлбэрээр гарах бөгөөд Конгресс өөрөөр шийдэхээс бусад тохиолдолд тухайн Конгресс явагдах үед шинэчлэгдсэн баримт бичгийн адил хугацаанд хүчин төгөлдөр болно. Гишүүн орнууд тэдгээрийг аль болох богино хугацаанд соёрхон батлах бөгөөд тийнхүү соёрхон батласан батламж жуух бичгийг 26 дугаар зүйлд заасан журмын дагуу хүргүүлнэ.

31 дүгээр зүйл⁶

Ерөнхий журам, конвенц, хэлэлцээрүүдэд оруулах нэмэлт өөрчлөлт

1. Ерөнхий журам, конвенц, хэлэлцээрүүд нь тэдгээртэй холбогдох саналыг батлах, бүрэн биелүүлэх нөхцлийг тодорхойлно.

2. 1 дэх хэсэгт дурдсан конвенц болон хэлэлцээрүүд нь нэгэн зэрэг хүчин төгөлдөр болж, ижил хугацааны туршид хүчин төгөлдөр үйлчилнэ. Эдгээр баримт бичгийн хүчин төгөлдөр болгох Конгрессийн товлосон өдрөөс эхлэн өмнөх Конгрессийн холбогдох баримт бичгүүд хүчингүй болно.⁷

¹ 1989 оны Вашингтон, 1994 оны Сөүлийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² 1999 оны Бээжингийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

³ 1969 оны Токио, 1989 оны Вашингтоны конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁴ 1999 оны Бээжингийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁵ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁶ 1984 оны Гамбургийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

⁷ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

IV Бүлэг

Маргаан шийдвэрлэх

32 дугаар зүйл

Арбитр

Холбооны баримт бичгийг тайлбарлахтай холбогдсон, эсхүл эдгээр баримт бичгийг хэрэгжүүлэх явцад шуудангийн захиргааны хүлээх үүрэгтэй холбогдон хоёр буюу түүнээс дээш гишүүн орнуудын шуудангийн байгууллагуудын хооронд маргаан гарвал уг асуудлыг арбитраар шийдвэрлүүлнэ.

III ХЭСЭГ

Төгсгөлийн заалтууд

33 дугаар зүйл¹

Дүрмийн үйлчилж эхлэх болон хүчин төгөлдөр байх хугацаа

Дүрэм нь 1966 оны 1дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд тодорхойгүй хугацаанд үйлчилнэ.

Үүнийг гэрчилж, хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид нэг эх хувь үйлдсэн энэхүү дүрэмд гарын үсэг зурж, Холбоо байрлах улсын засгийн газрын архивт хадгалуулна. Түүний хуулбарыг Дэлхийн шуудангийн холбооны Олон улсын товчооноос бүх талд хүргүүлнэ.

1964 он 7 дугаар сарын 10-ны өдөр, Вена хот

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН ХОЛБООНЫ ДҮРМИЙН ДОЛДУГААР НЭМЭЛТ ПРОТОКОЛ*

Бухарестийн конгрессоор чуулсан Дэлхийн шуудангийн холбооны гишүүн орнуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид Вена хотноо 1964 оны 7 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Дэлхийн шуудангийн холбооны Дүрмийн 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу соёрхон батлах нөхцлөөр Дүрэмд дараахь нэмэлт өөрчлөлтийг оруулав.

1 дүгээр зүйл

Нэмэлт өөрчлөлт оруулсан удиртгал

Шуудангийн үйлчилгээний үр өгөөжтэй үйл ажиллагааны дүнд ард түмнүүдийн хоорондын харилцааг хөгжүүлэх болон соёл, нийгэм, эдийн засгийн салбарт олон улсын хамтын ажиллагааны эрхэм зорилтуудад хүрэхэд амжилт олоход хувь нэмрээ оруулах зорилгоор хэлэлцэн тохирогч орнуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид соёрхон батлах нөхцлөөр энэхүү дүрмийг батлав.

Холбооны үүрэг нь дэлхийн шуудангийн үйлчилгээний чанарын үр ашигтай, тогтвортой хөгжлийг хангаж, дэлхийн хүмүүсийн хоорондын харилцааг дор дурдсан хэлбэрээр дэмжинэ:

- нягт холбогдсон сүлжээгээр шуудангийн нэг нутаг дэвсгэрийг бий болгож, түүгээр дамжуулан шуудангийн илгээмж чөлөөтэй солилцож байх баталгааг хангах;
- шударга, нийтлэг стандарт, технологийг хэрэглэж, ашиглахыг дэмжих;
- хувь нийлүүлэгчдийн хоорондох хамтын ажиллагаа, харилцан ойлголцлын баталгааг хангах;

- үр ашигтай техникийн хамтын ажиллагааг урамшуулах;
- хэрэглэгчдийн өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах арга хэмжээ авах.

2 дугаар зүйл

(1 bis дүгээр зүйл нэмэх)

Тодорхойлолтууд

- 1 Дэлхийн шуудангийн холбооны баримт бичгүүдийн зорилгоор дараахь нэр томъёо дор дурдсан утгатай байна:
 - 1.1 Шуудангийн үйлчилгээ: Холбооны байгууллагаас цар хүрээг нь тодорхойлсон бүхий л шуудангийн үйлчилгээ. Шуудангийн үйлчилгээний гол үүрэг нь шуудангийн илгээмжийг хүлээн авах, ангилал, дамжуулах, хүргэх зэргээр гишүүн орнуудын нийгэм, эдийн засгийн тодорхой зорилтуудыг хангахад чиглэнэ.
 - 1.2 Гишүүн орон: Дүрмийн 2 дугаар зүйлийг бүрэн хангах улс байна.
 - 1.3 Шуудангийн нэг нутаг дэвсгэр (шуудангийн нэг буюу ижил нутаг дэвсгэр): ДШХ-ны баримт бичгийн хэлэлцэн тохирогч талуудын захидал шууданг харилцан солилцох, чөлөөтэй дамжин өнгөрүүлэх, шуудангийн илгээмжийг нэг орноос нөгөө орон руу өөрийн шуудангийн илгээмжийн нэг адил алагчлахгүйгээр дамжин өнгөрүүлэх зэрэг үүрэг.
 - 1.4 Чөлөөтэй дамжин өнгөрүүлэх: нэг орноос ДШХ-ны гишүүн нөгөө орон руу шуудангийн

¹ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

* "Протоколд нэгдэн орсныг соёрхон батлах тухай" Монгол Улсын хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.

илгээмжийг тээвэрлэн өнгөрүүлж байгаа шуудангийн байгууллага нь уг илгээмжийг өөрийн орны шуудангийн илгээмжийн нэгэн адил нөхцлөөр дамжин өнгөрүүлэх үүрэг.

1.5 Захидал шуудангийн илгээмж: Конвенцид тодорхойлогдсон илгээмж.

1.6 Олон улсын шуудангийн үйлчилгээ: Баримт бичгүүдээр зохицуулагдах шуудангийн үйлчилгээ буюу үйл ажиллагаа; эдгээр үйлчилгээ буюу үйл ажиллагааны цогцгыг хэлнэ.

3 дугаар зүйл

(22 дугаар зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлт)

Холбооны баримт бичгүүд

1. Дүрэм нь Холбооны үндсэн баримт бичиг болно. Дүрэм нь Холбооны гол журмыг тогтоох бөгөөд **түүнд тайлбар хийхгүй.**¹

2. Ерөнхий журам нь Дүрмийг хэрэгжүүлэх болон Холбооны ажиллах журмыг хангах заалтуудыг тусгана. Түүнийг гишүүн бүх орон дагаж мөрдөх ёстой бөгөөд **түүнд тайлбар хийхгүй.**²

3. Дэлхийн шуудангийн холбооны дүрэм, Шуудангийн захидлын журам, Шуудангийн илгээмжийн журам нь олон улсын шуудангийн үйлчилгээнд хэрэглэх дүрэм болон шуудангийн захидал, шуудангийн илгээмжийн үйлчилгээтэй холбоотой хэм хэмжээг тусгана. Баримт бичгүүд нь гишүүн бүх орны хувьд заавал биелэгдэх хүчин төгөлдөр байна.

4. Холбооны хэлэлцээр болон түүний журмууд нь оролцогч тал болох гишүүн орнуудын хоорондох шуудангийн захидал болон шуудангийн илгээмжээс бусад үйлчилгээг зохицуулна. Мөн эдгээр нь зөвхөн тухайн орнуудад хүчинтэй байна.

5. Дүрэм болон хэлэлцээрийн хэрэгжүүлэхэд шаардлагатай журмыг тусгасан зохицуулалтуудыг Шуудангийн ашиглалтын зөвлөл батлах бөгөөд чингэхдээ Конгрессоос гаргасан шийдвэрүүдийг харгалзан үзнэ.

6. 3, 4, 5 дахь хэсгийн заалтад тусгагдсан Холбооны баримт бичгүүдэд хавсаргасан Төгсгөлийн протоколууд нь эдгээр баримт бичигт хийх тайлбарыг агуулна.

4 дүгээр зүйл

(30 дугаар зүйлд оруулсан нэмэлт өөрчлөлт)

Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт

1. Дүрэмтэй холбоотой Конгресст хүргүүлсэн саналыг Холбооны гишүүн санал **огөх эрхтэй** орнуудын гуравны хоёроос багагүй хувь нь дэмжсэнээр батлана.

2. Конгрессоос батласан нэмэлт өөрчлөлт нь нэмэлт протоколын хэлбэрээр гарах бөгөөд Конгресс өөрөөр шийдэхээс бусад тохиолдолд тухайн Конгресс явагдах үед шинэчлэгдсэн баримт

бичгийн адил хугацаанд хүчин төгөлдөр болно. Гишүүн орнууд тэдгээрийг аль болох богино хугацаанд соёрхон батлах бөгөөд тийнхүү соёрхон батласан батламж жуух бичгийг 26 дугаар зүйлд заасан журмын дагуу хүргүүлнэ.

5 дугаар зүйл

(31 дүгээр зүйлд оруулах нэмэлт өөрчлөлт)

Ерөнхий журам, конвенц, хэлэлцээрүүдэд оруулах нэмэлт өөрчлөлт

1. Ерөнхий журам, конвенц, хэлэлцээрүүд нь тэдгээртэй холбогдох саналыг батлах, бүрэн биелүүлэх нөхцлийг тодорхойлно.

2. 1 дэх хэсэгт дурдсан **конвенц болон хэлэлцээрүүд** нь нэгэн зэрэг хүчин төгөлдөр болж, нэгэн ижил хугацааны туршид хүчин төгөлдөр үйлчилнэ. Эдгээр баримт бичгийн хүчин төгөлдөр болгох Конгрессийн товлосон өдрөөс эхлэн өмнөх Конгрессийн холбогдох баримт бичгүүд хүчингүй болно.

6 дугаар зүйл

Нэмэлт протокол болон Холбооны бусад баримт бичигт нэгдэн орох

1. Энэхүү протоколд гарын үсэг зураагүй гишүүн орнууд ямар ч үед түүнд нэгдэн орж болно.

2. Конгрессоос шинэчилсэн баримт бичгийн оролцогч тал боловч түүнд гарын үсэг зураагүй гишүүн орнууд аль болох богино хугацаанд түүнд нэгдэж орно.

3. 1 болон 2 дахь хэсэгт дурдсан тохиолдолд нэгдэн орох тухай баримт бичгийг Олон улсын товчооны Ерөнхий захиралд хүргүүлэх бөгөөд тэрбээр баримт бичгийг хадгалсан тухай гишүүн орнуудын засгийн газарт мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Дэлхийн шуудангийн холбооны Дүрмийн нэмэлт протокол хүчин төгөлдөр болох, түүний үйлчлэх хугацаа

Энэхүү нэмэлт протокол нь **2006 оны 1дүгээр сарын 1-ний өдөр** хүчин төгөлдөр болж, тодорхойгүй хугацаанд үйлчилнэ.

Үүнийг гэрчилж, хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид Дүрмийн эх бичвэрт тусгасан ижил хүчинтэй, ижил хугацаанд үйлчлэх заалтууд бүхий энэхүү нэмэлт протоколыг үйлдэж, Олон улсын товчооны Ерөнхий захиралд хадгалуулах нэг эх хувьд гарын үсэг зурчгаав. Хуулбарыг **Дэлхийн шуудангийн холбооны Олон улсын товчоо** оролцогч тал бүрт хүргүүлнэ.

2004 оны 10 дугаар сарын 5-ны өдөр,

Бухарест хот

¹ 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

² 2004 оны Бухарестийн конгрессоор нэмэлт өөрчлөлт оруулсан

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ШУУДАНГИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭР*

Дор гарын үсэг зурагсад, Холбооны гишүүн орнуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид Вена хотноо 1964 оны 7 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан Дэлхийн шуудангийн холбооны Дүрмийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу нийтийн зөвшилцөлд хүрч, Дүрмийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцлөөр дараахь хэлэлцээрийг байгуулав.

I Бүлэг

Нийтлэг заалт

1 дүгээр зүйл

Хэлэлцээрийн зорилго болон холбогдох үйлчилгээ

1. Энэ хэлэлцээр нь мөнгө шилжүүлэгтэй холбоотой шуудангийн бүхий л үйлчилгээг зохицуулна. Хэлэлцэн тохирогч орнууд энэхүү хэлэлцээрт дурдсан үйлчилгээг харилцан адил байх харилцаанддаа эрхлэх тухай харилцан тохиролцоно.

2. Шуудангийн бус байгууллагууд нь шуудангийн байгууллагаар дамжуулан энэхүү хэлэлцээрийн заалтуудаар зохицуулагдах *giro* үйлчилгээ буюу шуудангийн санхүүгийн шилжүүлэг хийх сүлжээний үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож болно. Тэдгээр байгууллага нь өөрийн орны шуудангийн байгууллагатай энэхүү хэлэлцээрийн бүх заалтыг биелүүлэх талаар хэлцэл байгуулах бөгөөд уг хэлцэл нь энэхүү хэлэлцээрээр тогтоосон шуудангийн байгууллагын эрхийн хэрэгжилтийг хангаж, үүргийг гүйцэтгүүлнэ. Шуудангийн байгууллага нь хэлэлцэн тохирогч бусад орны шуудангийн байгууллага болон Олон улсын товчоотой харилцах харилцаанд зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү хэлэлцээрт тодорхойлсон санхүүгийн үйлчилгээг үзүүлдэггүй, эсхүл үйлчилгээ нь хэрэглэгчдийн шаардлагад нийцдэггүй шуудангийн байгууллага тухайн орон дахь шуудангийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

3. Гишүүн орнууд шуудангийн санхүүгийн үйлчилгээ хариуцсан төрийн байгууллагын нэр, хаяг, шуудангийн санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болон тухайн нутаг дэвсгэрт Холбооны баримт бичгүүдээс үүдсэн үүргийг бүрэн биелүүлэхээр албан ёсоор томилсон оператор, эсхүл операторуудын нэр, хагийг Конгресс хуралдсанаас хойш зургаан сарын дотор Олон улсын товчоонд хүргүүлнэ.

3.1. Гишүүн орнууд шуудангийн санхүүгийн үйлчилгээ болон лавлах үйлчилгээний үйл ажиллагааг хариуцсан этгээдүүдтэй холбоо барих дэлгэрэнгүй мэдээллийг Конгресс хуралдсанаас хойш зургаан сарын дотор Олон улсын товчоонд хүргүүлнэ.

3.2. Конгрессуудын хооронд засгийн газрын байгууллага, албан ёсоор томилсон операторууд болон хариуцсан этгээдүүд өөрчлөгдсөн бол энэ талаар Олон улсын товчоонд аль болох хурдан мэдэгдэнэ.

4. Энэхүү хэлэлцээрээр шуудангийн төлбөрийн дараахь үйлчилгээг зохицуулна:

4.1. ногдуулсан төлбөрийн (НТ) мөнгөн гуйвуулгыг оролцуулан шуудангийн мөнгөн гуйвуулга;

4.2. данс хоорондын шилжүүлэг.

5. Шуудангийн холбогдох байгууллагууд хоорондын хоёр талт буку олон талт хэлэлцээрээр бусад үйлчилгээг тогтоож болно.

II Бүлэг

Шуудангийн мөнгөн гуйвуулга

2 дугаар зүйл

Үйлчилгээний тодорхойлолт

1. Энгийн мөнгөн гуйвуулга

1.1. Гуйвуулах хэрэглэгч нь шуудангийн байгууллагын кассанд мөнгөө шилжүүлэх буюу өөрийн данснаас гаргуулж, ямар нэг шимтгэлгүйгээр нийт мөнгөн дүнг төлбөр хүлээн авагчид шилжүүлэх талаар хүсэлт гаргана.

2. Төлбөрийн бус мөнгөн гуйвуулга

2.1. Гуйвуулах хэрэглэгч нь шуудангийн салбарын кассанд мөнгөө шилжүүлж, шуудангийн байгууллагын мэдлийн төлбөр хүлээн авагчийн дансанд буюу санхүүгийн бусад байгууллагын мэдлийн дансанд ямар нэг шимтгэлгүйгээр тухайн мөнгийг шилжүүлэхийг тэднээс хүсч болно.

3. Ногдуулсан төлбөрийн мөнгөн гуйвуулга

3.1 "Ногдуулсан төлбөрийн" мөнгөн гуйвуулгыг хүлээн авагч нь мөнгөө

* "Хэлэлцээрт нэгдэн орсныг соёрхон батлах тухай" Монгол Улсын хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.

шилжүүлэх буюу өөрийн данснаас гаргуулж, ямар нэг шимтгэлгүйгээр нийт мөнгөн дүнг "ногдуулсан төлбөрийн" илгээгчид шилжүүлэх талаар хүсэлт гаргана.

3 дугаар зүйл

Гуйвуулга хийх

1. Тусгай хэлэлцээр байхгүй тохиолдолд шуудангийн мөнгөн гуйвуулгын дүн нь тухайн шилжиж очих орны мөнгөний нэгжээр илэрхийлэгдэнэ.

2. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь шилжиж очих орны мөнгөний нэгжид өөрийн шилжүүлэх мөнгөний нэгжийн ханшийг тогтооно.

3 Шуудангийн мөнгөн гуйвуулгын дээд хэмжээг хоёр талын тохиролцсоны дагуу тогтооно.

4 Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь шуудангийн мөнгөн гуйвуулга хийх бичиг баримт болон хэлбэрийг чөлөөтэй тогтооно. Хэрэв мөнгөн гуйвуулгыг шуудангаар шилжүүлэхээр бол зөвхөн Журмаар тогтоосон маягтуудыг ашиглана.

4 дүгээр зүйл

Хураамж

1. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь шилжүүлэг хийх үеийн хураамжийг чөлөөтэй тогтооно.

2. Энэхүү хэлэлцээрт оролцогч орны зуучлалаар дамжуулан хэлэлцэн тохирогч орон болон хэлэлцэн тохирогч бус орны хооронд хийгдэх шуудангийн мөнгөн гуйвуулгаас тухайн үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал дээр үндэслэж тогтоосон нэмэлт хураамжийг шуудангийн зуучлагч байгууллага авч болно. Уг хураамжийн хэмжээг холбогдох болон шуудангийн мөнгөн гуйвуулгаас хураамж авч буй шуудангийн байгууллагууд хоорондоо тохиролцоно. Хэрэв шуудангийн холбогдох байгууллагууд тохиролцсон бол уг хураамжийг илгээгчээс авч, зуучлагч улсын шуудангийн байгууллагад байршуулж болно.

3. Шуудангийн байгууллагуудын хооронд RL 110, ба 111 дүгээр зүйлд заасан нөхцлийн дагуу шуудангаар хийх шуудангийн мөнгөн гуйвуулгын шилжүүлэгэнд хамсаргах баримт бичиг, хэрэгсэл болон төлбөрийн даалгаврууд бүх шимтгэлээс чөлөөлөгдөнө.

5 дугаар зүйл

Шилжүүлэг хийх шуудангийн байгууллагын үүрэг

1. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэхийн тулд Журмуудад заасан үйлчилгээний стандартыг хангасан байна.

6 дугаар зүйл

Гуйвуулгын гүйлгээ

1. Мөнгөн гуйвуулгын шилжүүлгийг ДШХ-ны Олон улсын товчоо, эсхүл бусад байгууллагаас хангасан цахим сүлжээгээр хийнэ.

2. Цахим шилжүүлгийг төлбөр шууд хийх байгууллага буюу шилжүүлэг хийх алба хийнэ. Шилжүүлгийн аюулгүй байдал, чанарын баталгааг хэрэглэгдэж буй сүлжээнд хамаарах техникийн үзүүлэлт, эсхүл шуудангийн байгууллага хоорондын хоёр талт хэлэлцээрийн аль нэгээр хангана.

3. Шуудангийн байгууллагууд нь мөнгөн гуйвуулгын шилжүүлгийг Журмуудаар тогтоосон цаасан хэлбэрээр болон баталгаат шуудангаар хийх талаар тохиролцож болно.

4. Шуудангийн байгууллагууд нь шилжүүлгийн бусад хэлбэрийг ашиглах талаар тохиролцож болно.

7 дугаар зүйл

Хүлээн авагч орны нөхцөл

1. Шуудангийн мөнгөн гуйвуулгыг хүлээн авагч орны хууль тогтоомжоор зохицуулна.

2. Нийтлэг зарчмын дагуу шуудангийн мөнгөн гуйвуулгын нийт дүнг төлбөр хүлээн авагчид төлөх бөгөөд хэрэв төлбөр хүлээн авагч нэмэлт тусгай үйлчилгээ хүсвэл нэмэлт хураамж тогтоож болно.

3. Цахим шуудангийн мөнгөн гуйвуулгын хүчин төгөлдөр байх хугацааг хоёр талт хэлэлцээрийн дагуу тогтооно.

4. Цаасан хэлбэрээр хийгдсэн шуудангийн мөнгөн гуйвуулгын хүчинтэй хугацааг нийтлэг зарчмын дагуу шилжүүлэг хийсэн сарын дараах сарын сүүл хүртэл хугацаанд сунгана.

5. Дээр дурдсан хугацаанаас хойш төлөгдөөгүй шуудангийн мөнгөн гуйвуулга

шилжүүлэг хийх шуудангийн байгууллагад шууд буцаагдах ёстой.

8 дугаар зүйл

Төлбөр хийх шуудангийн байгууллагын үйлчилгээний хураамж

1. Шуудангийн мөнгөн гуйвуулгыг хийх бүрт шилжүүлэг хийх шуудангийн байгууллага төлбөрийг хийх шуудангийн байгууллагад хувийг нь Журмуудаар тогтоосон үйлчилгээний хураамж төлнө.

2. Журмаар тэнцүүлж тогтоосон хувиас өөр үйлчилгээний хураамжийн хувийг шуудангийн байгууллагууд тохиролцож болно.

3. Хураамжгүй хийсэн мөнгөн гуйвуулгын шилжүүлэг үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөх нөхцөл болно.

4. Шуудангийн холбогдох байгууллагууд зөвшөөрсөн тохиолдолд шилжүүлэг хийх шуудангийн байгууллагаас хураамж аваагүй тусламжийн мөнгөн гуйвуулгын шилжүүлгүүд нь үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөнө.

9 дүгээр зүйл

Төлбөр хийх шуудангийн байгууллагын үүрэг

1. Төлбөр хийх шуудангийн захиргаа нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг хангахын тулд Журмуудаар тогтоосон үйлчилгээний стандартыг хангасан байна.

III Бүлэг

Шуудангийн шилжүүлгүүд

10 дугаар зүйл

Үйлчилгээний тодорхойлолт

1. Шуудангийн данс эзэмшигч өөрийн данснаас төлбөр хийх, шуудангийн байгууллагын мэдлийн төлбөр хүлээн авагчийн данс уруу болон хүлээн авагч орны шуудангийн байгууллагаар дамжуулан өөр данс уруу төлбөр хийлгэхээр хандаж болно.

11 дүгээр зүйл

Гуйвуулга хийх

1. Шилжүүлгийн дүн нь хүлээн авагч орны мөнгөн тэмдэгтээр буюу хүлээн авагч болон төлбөр

хийгч шуудангийн байгууллага хоорондын хэлэлцээрт тусгагдсан мөнгөний бусад нэгжээр илэрхийлэгдсэн байна.

2. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь шилжүүлгэнд илэрхийлэгдсэн мөнгөний нэгжид хөрвүүлэх өөрийн мөнгөний нэгжийн хөрвөх ханшийг тогтооно.

3. Шилжүүлгийн нийт дүн нь шуудангийн холбогдох байгууллагууд өөрөөр тогтоогоогүй бол ямар нэг хязгааргүй байна.

4. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь шилжүүлэг хийх баримт бичиг болон хэлбэрийг чөлөөтэй тогтооно.

12 дугаар зүйл

Хураамж

1. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага шилжүүлэх үеийн хураамжийг чөлөөтэй тогтооно. Хураамжийн энэ зарчмаар илгээгчид үзүүлсэн тусгай үйлчилгээний хураамжийг нэмж авна.

2. Энэхүү хэлэлцээрийн оролцогч тал болох орноор зуучлуулан хэлэлцэн тохирогч тал болон хэлэлцэн тохирогч бус талын хооронд хийгдэх мөнгөн гүйлгээний шилжүүлэгт зуучлагч байгууллагаас нэмэлт шимтгэл авч болно. Энэхүү хураамжийн дүнг шуудангийн холбогдох байгууллагууд тохиролцох бөгөөд тухайн шилжүүлгийн дүнгээс хасаж тооцно. Уг хураамжийг илгээгчээс авч болох бөгөөд хэрэв шуудангийн холбогдох байгууллагууд тийнхүү тохиролцсон бол зуучлагч орны шуудангийн байгууллагад байршуулж болно.

3. RL 110, болон 111 дүгээр зүйлд заасан нөхцлийн дагуу шуудангийн байгууллагуудын хооронд шуудангаар хийгдэх шуудангийн мөнгөн гуйвуулгын шилжүүлгэнд холбогдох баримт бичиг, хэрэгсэл болон төлбөрийн даалгаврууд бүх шимтгэлээс чөлөөлөгдөнө.

13 дугаар зүйл

Шилжүүлэг хийх шуудангийн байгууллагын үүрэг

1. Шилжүүлэг хийх шуудангийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхийн тулд Журмуудаар тогтоосон үйлчилгээний стандартыг хангасан байна.

14 дүгээр зүйл

Гуйвуулгын гүйлгээ

1. Шилжүүлгийг шуудангийн холбогдох байгууллагуудаас батласан техникийн үзүүлэлтэнд тулгуурлан ДШХ-ны Олон улсын товчоо, эсхүл бусад байгууллагаас хангасан цахим сүлжээгээр хийнэ.

2. Шилжүүлгийн аюулгүй байдал, чанарын баталгааг хэрэглэгдэж буй сүлжээнд хамаарах техникийн үзүүлэлт, эсхүл шилжүүлэх хийх болон төлбөр хийх шуудангийн байгууллага хоорондын хоёр талт хэлэлцээрийн аль нэгээр хангана.

3. Шуудангийн байгууллагууд нь шилжүүлгийг Журмуудаар тогтоосон цаасан хэлбэрээр болон баталгаат шуудангаар хийх талаар тохиролцож болно.

4. Шуудангийн байгууллагууд нь шилжүүлгийн бусад хэлбэрийг ашиглах талаар тохиролцож болно.

15 дугаар зүйл

Хүлээн авагч орны нөхцөл

1. Ирж байгаа шилжүүлэгт нь хүлээн авагч орны хууль тогтоомжид заасан нөхцөл олгоно.

2. Нийтлэг зарчмын дагуу төлбөрийг хүлээн авах орон дахь хүлээн авагч төлөх боловч хоёр талын хэлэлцээрт заасны дагуу уг төлбөрийг илгээгчээс авч хүлээн авагч орны шуудангийн байгууллагад байршуулна.

16 дугаар зүйл

Төлбөр хийх шуудангийн байгууллагын үйлчилгээний хураамж

1. Шилжүүлэг хийх бүрт төлбөр хийх шуудангийн байгууллага шилжүүлсний хураамж төлөхийг хүсэж болно. Уг хураамж нь төлбөр хүлээн авагчийн дансанд орох, эсхүл шилжүүлэг хийх шуудангийн байгууллагын харилцах дансанд тусгагдсан байна.

2. Хураамжгүй хийсэн мөнгөн гуйвуулгын шилжүүлэг үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөх нөхцөл болно.

3. Шуудангийн холбогдох байгууллагууд зөвшөөрсөн тохиолдолд шилжүүлэг хийх шуудангийн байгууллагаас хураамж аваагүй тусламжийн мөнгөн гуйвуулгын шилжүүлгүүд нь үйлчилгээний хураамжаас чөлөөлөгдөнө.

17 дугаар зүйл

Төлбөр хийх шуудангийн байгууллагын үүрэг

1. Төлбөр хийх шуудангийн байгууллага нь хэрэглэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээг үзүүлэхийн тулд Журмуудаар тогтоосон үйлчилгээний стандартыг хангасан байна.

IV Бүлэг

Харилцах данс, сар тутмын данс, лавлагаа, хариуцлага

18 дугаар зүйл

Оролцогч шуудангийн байгууллага хоорондын санхүүгийн харилцаа

1. Шуудангийн байгууллагууд нь өөрсдийн өр төлбөрийг шийдвэрлэх техникийн аргачлалын талаар нэг нэгтэйгээ харилцан зөвшилцөнө.

2. Харилцах данс

2.1. **Нийтлэг зарчмын дагуу** шуудангийн байгууллагууд нь *giro* бүтэцтэй бол шилжүүлэг, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ болон шуудангийн байгууллагуудын бусад үйл ажиллагаанаас үүдсэн өөр хоорондын өр төлбөр, нэхэмжлэлийг барагдуулах талаар холбоо тогтоох байгууллагатай хамтран өөрийн нэрийн өмнөөс харилцах данс нээх замаар уг асуудлыг шийдвэрлэх талаар шуудангийн байгууллагууд тохиролцож болно.

2.2. Хүлээн авагч орны шуудангийн байгууллага *giro* бүтэцгүй бол харилцах дансыг шуудангийн өөр байгууллагатай хамтран нээж болно.

2.3. Шуудангийн байгууллагууд олон талт хэлэлцээрийг үндэслэн тодорхой байгууллагаар дамжуулан санхүүгийн гүйлгээ хийх талаар тохиролцож болно.

2.4. Харилцах дансны гүйлгээ хэтэрсэн тохиолдолд Жүрамд заасан хүүг тухайн илүү гарсан мөнгөнөөс төлнө.

2.5. Харилцах дансан дахь төлөгдөөгүй үлдэгдлээс хүүгийн орлого авахыг зөвшөөрнө.

3. Сар тутмын данс

3.1. Харилцах данс байхгүй тохиолдолд төлбөр хийх шуудангийн байгууллага 5-р шилжүүлэг хийх шуудангийн байгууллага бүрт зориулан мөнгөн гуйвуулгуудад төлөгдсөн нийт

хэмжээг үзүүлсэн сар тутмын данс бэлтгэнэ. Сар тутмын дансыг балансын дүнг тодорхойлох нөхөн төлбөрийн дансны нийт үлдэгдэлд тогтмол тусгаж байна.

3.2. Данстай холбоотой асуудлыг нөхөн төлбөр хийлгүйгээр сар тутмын дансыг үндэслэн шийдвэрлэж болно.

4. Төлбөр төлөх хугацааг албан ёсоор хойшлуулах, гуйвуулга хийхэд хориг тавих зэрэг өрөөсгөл арга хэмжээ нь энэ зүйл болон Журмуудын заалтуудад нөлөөлөхгүй.

19 дүгээр зүйл

Лавлагаа

1. Шуудангийн мөнгөн гуйвуулга шуудангаар илгээсэн буюу шилжүүлэг хийсний дараахь өдрөөс хойш зургаан сарын доторх хугацаанд лавлагаа хийж болно.

2. Шуудангийн байгууллага нь шуудангийн мөнгөн гуйвуулга, эсхүл шилжүүлгийн талаар лавлагаа хийснийхээ хураамжийг хэрэглэгчдээс авах эрхтэй.

20 дугаар зүйл

Хариуцлага

1. Хүлээх хариуцлага болон зарчим

1.1. Шуудангийн байгууллага нь мөнгөн гуйвуулга хийсэн хугацаа буюу хүлээн авагчийн дансанд төлбөр бүрэн орох хүртэл хугацаанд төлбөр төлөгчийн дансны мөнгөн дүнг төлөх үүрэгтэй хэвээр байна.

1.2. Шуудангийн байгууллага нь төлбөр үл хийгдэх, эсхүл мөнгөн гуйвуулгын шилжүүлгийн гүйцэтгэлд алдаа гарснаас шалтгаалан гарсан алдаатай мэдээллийн төлөө хариуцлага хүлээнэ. Мөн харилцаанд гарсан алдаа болон шилжүүлгэнд гарсан алдааны төлөө хариуцлага хүлээнэ.

1.3. Шуудангийн байгууллага нь дараахь хариуцлагаас чөлөөлөгдөж болно:

1.3.1. гуйвуулга болон баримт бичгийн гүйлгээ, шилжүүлэг төлбөр тооцоонд учирсан саатал;

1.3.2. давагдашгүй хүчин зүйлээс улбаалан албан харилцаанд саад учран тэдгээрийн хариуцлагыг өөрөөр хүлээлгэнэ гэж нотлохоос бусад үед мөнгөн гуйвуулгын шилжүүлгийн тооцоо хийж чадахгүй байгаа тохиолдолд;

1.3.3. төлбөр хийгч нь 19 дүгээр зүйлд заасан хугацааны дотор гомдол гаргаагүй бол;

1.3.4. мөнгөн гуйвуулгын тогтоосон хугацааг шилжүүлэх орон сунгасан бол.

1.4. Ямар нэг шалтгаангүйгээр түүнийг буцаан олгох тохиолдолд илгээгчид буцаан олгосон мөнгөний нийт хэмжээ түүний төлсөн, эсхүл данснаасаа гаргасан мөнгөний хэмжээнээс хэтэрч болохгүй.

1.5. Шуудангийн байгууллагууд нь тэдний дотоод үйлчилгээний шаардлагад тохирсон хариуцлагын илүү өргөн нөхцлийг хэрэглэх талаар өөр хоорондоо тохиролцож болно.

1.6. Хариуцлага хүлээлгэх зарчмуудыг хэрэглэх нөхцөл, ялангуяа хариуцлагыг тодорхойлох асуудал, хэтэрсэн мөнгийг буцаан олгох, тусламж авах, нөхөн төлбөр төлсөн байгууллагад төлбөр тооцоо болон буцаан олголт хийхийг зөвшөөрсөн хугацаа зэргийг Журмаар тогтооно.

V Бүлэг

Цахим сүлжээ

21 дүгээр зүйл

Нийтлэг зарчим

1. Төлбөрийн шилжүүлгийг цахим хэрэгслээр хийхийн тулд шуудангийн байгууллагууд ДШХ-ны сүлжээ, эсхүл хурдан, найдвартай, аюулгүй байдал нь хангагдсан өөр бусад зөвшөөрөгдсөн сүлжээг ашиглана.

2. ДШХ-ны санхүүгийн цахим үйлчилгээг шуудангийн байгууллага хоорондын хоёр талын хэлэлцээрийг үндэслэн зохицуулна ДШХ-ны санхүүгийн цахим үйлчилгээ нь Холбооны баримт бичгүүдэд нийцсэн байна.

VI Бүлэг

Бусад заалт

22 дугаар зүйл

Гадаадад giro данс нээхээр мэдүүлэх

1. Гадаадад giro болон бусад данс нээх буюу санхүүгийн бусад үйлчилгээг гадаадад хийхээр бол энэ хэлэлцээрийн хэлэлцэн тохирогч орнуудын шуудангийн байгууллагууд эдгээр үйлчилгээ эрхлэх тухай мэдүүлэг өгөхөд туслалцаа үзүүлэх талаар тохиролцоно.

2. Талууд өөр хоорондоо үзүүлж болох туслалцааны мэдүүлэг өгөх дэлгэрэнгүй журам болон уг туслалцааг үзүүлэхэд гарах зардлын талаар хоёр талаараа тохиролцоно.

VII Бүлэг

Төгсгөлийн заалтууд

23 дугаар зүйл

1. Энэхүү хэлэлцээрээр шууд зохицуулаагүй бүх тохиолдолд шаардлагатай гэж үзвэл Конвенцийг түүний нэгэн адил хэрэглэнэ.

2. Дүрмийн 4 дүгээр зүйл энэхүү хэлэлцээрт хамаарахгүй.

3. Энэхүү хэлэлцээр болон **Журмуудтай** холбогдсон саналуудыг батлах нөхцөл нь:

3.1. Энэхүү хэлэлцээртэй холбогдсон Конгресст хүргүүлсэн санал нь энэхүү хэлэлцээрийн оролцогч тал бөгөөд **санал өгөх эрхтэй, санал хураалтад** оролцож буй гишүүн орнуудын олонх нь батласнаар хүчин төгөлдөр болж үйлчилнэ. Конгресст хүрэлцэн ирсэн **санал өгөх эрхтэй** эдгээр гишүүн орны хамгийн багадаа тал хувь нь санал хураах үед байлцах ёстой.

3.2. Энэхүү хэлэлцээртэй холбогдох журмуудад оруулах санал нь энэхүү хэлэлцээрийн оролцогч тал бөгөөд **санал өгөх эрхтэй** Шуудангийн ашиглалын зөвлөлийн гишүүдийн олонх батласнаар хүчин төгөлдөр болж үйлчилнэ.

3.3. Хоёр Конгрессийн хооронд энэхүү хэлэлцээртэй холбогдон гарах санал нь дараахь шаардлагыг хангасан тохиолдолд хүчин төгөлдөр болно:

3.3.1. хэрэв тэдгээр нь шинэ нэмэлт заалттай холбоотой бол энэхүү хэлэлцээрийн оролцогч тал бөгөөд **санал өгөх эрхтэй, санал хураалтад** оролцож буй гишүүн орнуудын хамгийн багадаа тал хувийх нь саналын гуравны хоёрыг;

3.3.2. хэрэв энэхүү хэлэлцээрийн заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулахаар бол энэхүү хэлэлцээрийн оролцогч тал бөгөөд **санал өгөх эрхтэй, санал хураалтад** оролцож буй гишүүн орнуудын хамгийн багадаа тал хувийх нь саналын ихэнх хэсгийг;

3.3.3. хэрэв энэхүү хэлэлцээрийн заалтуудыг тайлбарлах бол олонхийн саналыг тус тус авсан бол.

3.4. Нэмэлт болгож буй санал гишүүн орнуудын үндэсний хууль тогтоомжид нийцэхгүй бол уг нэмэлтийг батлахгүй байх тухай мэдэгдлийг Олон улсын товчооны Ерөнхий нарийн бичгийн даргад 90 хоногийн дотор мэдэгдэх эрхийг 3.3.1-ийн заалт хөндөхгүй.

4. Энэхүү хэлэлцээр нь **2006 оны 1 дүгээр сарын 1-ний** өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд дараагийн Конгрессийн баримт бичгүүд хүчин төгөлдөр болох хүртэл үйлчилнэ.

Үүнийг гэрчилж, хэлэлцэн тохирогч улсуудын засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчид энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурж, Олон улсын товчооны Ерөнхий захиралд хадгалуулах нэг эх хувьд гарын үсэг зурцаав. Хуулбарыг **Дэлхийн шуудангийн холбооны Олон улсын товчоо** оролцогч тал бүрт хүргүүлнэ.

2004 оны 10 дугаар сарын 5-ны өдөр,
Бухарест хотод үйлдэв.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хөвлөх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3